



**УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭЛЭГ  
СУДЛАЛЫН КЛИНИК ТӨВИЙН ҮҮСГЭН  
БАЙГУУЛАГДСАН ТҮҮХ**

**Улаанбаатар хот**

# МЭНДЧИЛГЭЭ



**ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Ж.ХАТАНБААТАР**  
*/Монгол Улсын Ардын эмч,  
АУ-ны Доктор. Профессор/*

Манай эмнэлэг нь 1989 онд үйл ажиллагаагаа ЭНЭШУНТөвд Монгол Улсын хэмжээнд уламжлалт анагаах ухааны анхны эмнэлэг билээ. Тус клиник төв нь "Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлого"-ын хүрээнд уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны шилдэг ололттой хослуулан хөгжүүлж, эрүүл мэндийг хамгаалах технологийн дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээг чанар хүртээмжийн өндөр түвшинд явуулж олны талархалыг хүлээн ажилласанаар өдгөө 20 гаруй жилийг өнгөрүүлжээ.

УАУ-ны ЭСКТөв буюу олноо "Хатанбаатар"-ын эмнэлэг хэмээн танигдсан хамт олон бид Монгол Улсын Эрүүл Мэндийн Системд Шинэ бодлого, Шинэ бүтэц, зохион байгуулалт, Шинэ менежментийг бий болгосондоо бахархалтай байдаг билээ. Манай эмнэлгийн тусламж үйлчилгээний давуу тал болох Дорнын анагаах гайхамшигт увидас болсон бие сэтгэлийг хамтад нь эмчлэн илааршуулдгаараа онцлогтой.

Манай клиник төв нь Уламжлалт Анагаах Ухааны гайхамшиг болсон зуун зуунаар дамжин ирсэн жор найрлагын дагуу байгалийн нэн цэвэр бүтээгдэхүүнээр бэлтгэж орчин үеийн шилдэг технологээр бүтээгдсэн эм бэлдмэлээр ард түмнийхээ эрүүл мэндийн төлөөх үйлсэд зүтгэж байна.

**ЭРХЭМ ТА БҮХЭНДЭЭ УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ  
ЭЛЭГ СУДЛАЛЫН КЛИНИК ТӨВИЙН ХАМТ ОЛНЫ ӨМНӨӨС  
ХАМГИЙН САЙН САЙХАН БҮХНИЙГ ХҮСЭН ЕРӨӨЕ.**



Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв нь 1989 оны 1 дүгээр сард ЭНЭШУНТөвийн захирал Д.Малчинхүүгийн тушаалаар эмэгтэйчүүдийн клиникийн зүрхний их эмч Ж.Хатанбаатарт ардын эмнэлгийн эмчилгээний кабинет байгуулан ажиллахыг зөвшөөрснөөр тус төв байгуулагдах үндэс суурь нь тавигджээ.

Ийнхүү байгуулагдсан ардын уламжлалт эмчилгээний кабинетийг 1989 оны 6 дугаар сард МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны

гишүүн П.Дамдин, ЭМЯ-ны орлогч сайд Мөнхөө, УБ хотын АДХГЗ-ын орлогч дарга Л.Энэбиш нарын хүмүүс үзэж үйл ажиллагаатай нь танилцаж эмчлүүлж буй хүмүүсийн сэтгэгдлийг сонсож цаашид дэмжиж ажиллахыг ЭМЯ, УБ хотын АДХГЗ болон ЭНЭШУНТөвд санал болгосны дагуу 1989 оны 10-р сард ЭНЭШУНТөвийн захирлын тушаалаар эмэгтэйчүүдийн клиникийн ардын эмчилгээний кабинетыг өргөтгөж "Ардын эмнэлэг нөхөн сэргээх эмчилгээний клиник"-ийг үзлэг, хануур, самнуур, бариа засал, зүү төөнүүр зэрэг эмчилгээтэйгээр байгуулан клиникийн эрхлэгчээр ардын эмчилгээний кабинетийн эмч Ж.Хатанбаатарыг томилж ажиллуулснаар олон арван жил зовсон олон түмэнд уламжлалт эмчилгээг ил тод хүргэж чадахгүй болтлоо шахагдан хавчигдаж байсан ардын уламжлалт эмчилгээг ард олонд хүргэх шинэ бөгөөд нүсэр ажлын эхлэлийг тавиад эмчилгээний дагнасан хэлбэрийг хосолсон эмийн салбарт шинэчлэлийг бодитойгоор авч ирсэн үйл явц болсон билээ.

ЭНЭШУНТөвийн захирлын тушаалаар эмэгтэйчүүдийн клиникийн эрхлэгч Ж.Хатанбаатарын саналыг үндэслэн, эмчилгээний ач холбогдлыг үнэлж цаашдын эмчилгээнд зайлшгүй шаардлагатай байгаа гадаад орноос авдаг түүхий эдийг авах уламжлалт эмийг өөрийн клиникийн баазад түшиглэн хийх зорилгоор БНЭУ-д томилон ажиллуулж, 78 нэр төрлийн 200 гаруй кг уламжлалт эмийн найрлагад ордог түүхий эдийг авч ирэн 3-5 төрлийн тан, 10-12 төрлийн уламжлалт эм хийж эмчилгээнд ашигласнаар тус төвийн эмийн үйлдвэрийн суурь тавигджээ.

1990 оны 10 сард "Ардын эмнэлгийн клиник"-ийг ЭНЭШУНТөвийн хүүхдийн клиник сувилалын баруун жигүүрийн 1, 2 дугаар давхарт байрлуулан стационарын 15 ортой, амбулаторийн 3 кабинеттай, эмийн жижиг цехтэйгээр өргөтгөн үйл ажиллагааг нь дэмжлээ.

"Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Эрүүлийг хамгаалах, нийгэм хангамжийн яамны сайдын 1991 оны 01 сарын 30 өдрийн А/11 тоот тушаалаар "Монголын уламжлалт анагаах ухааны Элэгний эмгэг эмчлэх монгол эмнэлгийг байгуулж батлагдсан журмын дагуу ажиллуулахыг ЭНЭШУНТ /н.Малчинхүү/, тэргүүн дэд сайд /н.Дашзэвэг/-нарт даалгасан шийдвэр гаргаж, Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх 1991-1995 оны үндсэн чиглэлийг баталсан нь төрөөс УАУ-ыг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан анхны үр дүнтэй ажил болжээ.

Уг үндсэн чиглэлд:

- Хүүхэд, насанд хүрэгчдийн дунд түгээмэл байгаа элэгний архаг өвчнийг эмчлэх, шинэ эм бэлдмэлийг судалж, эмнэлгийн практикт нэвтрүүлэх,

- Элэгний архаг өвчнийг эмчлэх, оношлох уламжлалт эмчилгээ, оношлогооны арга барил, нэгдсэн журмыг боловсруулах,
- Вируст гепатиттай тэмцэх хөтөлбөртэй уялдуулж элэгний өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх ажилд биечлэн оролцох,
- Монгол эмнэлгийн бусад салбарын элэгний өвчнийг эмчлэх нэгдсэн аргачлал, удирдамжаар хангаж ажиллахыг заажээ.



1991 оны 2-р сарын 4 –нд ЭМЯ, УБ хотын АДХГЗ-ын хамтарсан тушаал, тогтоолоор "Элэгний Эмгэг Эмчлэх Монгол Эмнэлэг"-ийг УБ хотын АДХГЗ-ын шууд харъяалалд ажиллуулан, захирлаар нь Ж.Хатанбаатарыг томилж, мэргэжлийн дээд удирдлага нь ЭМЯ-д, өдөр тутмын шуурхай удирдлагыг хотын захиргаанд шууд харъяалуулж стационарын 30 ортой эмчилгээний тасаг, амбулаторийн 5 кабинет, эмийн жижиг цехтэйгээр ажиллуулж эхэлсэн нь УАУ-ны анхны биеэ даасан төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг болсон юм.

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1993.04.15-ны өдрийн А/67 тоот захирамжаар Элэгний эмгэг эмчлэх Монгол эмнэлгийг Элэгний Эмгэг Эмчлэх Монгол Эмнэлэг, Төв болгон зохион байгуулж, эмчилгээний 60 ортой, амбулаторийн 14 кабинеттай, эмийн үйлдвэр, эмчилгээний дараах гам заслын 30 ор бүхий сувилалтай болгон өргөтгөсөн.

Тус эмнэлэг нь монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх төрийн бодлогын үндсэн дээр улсын хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа анхны төв болжээ.

Энэ үед тус төв нь эмчилгээний тасагтаа 667 хүн хэвтүүлэн эмчлэн 19980 ор хоног ашиглаж, орны эргэлт 21-30 хоног байсан нь эмчилгээний үр дүн сайн, хөдөлмөрчдийн талархлыг хүлээж, амбулаториор 19298 хүн эмчилж үүнээс давхардсан тоогоор 402 хүнийг диспансерын хяналтанд авч 30 хүнийг бүрэн эдгэрүүлж шинээр 308 хүнийг авч эмчилж, эмчлэгдэж буй бүх хүний 80%-д монгол эм, тангаар эмчилж, эмчилгээнд хэрэглэгдэх эмийн түүхий эдийн 70%-ийг дотоодоос, 30% гадаадаас бэлдэж өөрийн эмийн үйлдвэртээ эм тангаа үйлдвэрлэж эмчлүүлэгсдэд эмч нарын зааврын дагуу цаг хугацаанд нь тун хэмжээгээр нь эмчилгээний тасагт өвчний түүхээр, амбулаториор эмийн сангийн журмаар үйлчлэхийн зэрэгцээ эмийн бус эмчилгээгээр иог, зүү, төөнүүр, шавар эмчилгээ, биомассаж, эмэгтэйчүүд гэх мэт кабинетуудад байнгын үйлчилгээ явуулдаг байжээ.

БНЭУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, Монголд суугаа дипломат корпусуудын тэргүүн К.Бакула Ренбучи тус эмнэлгийн үйл ажиллагаатай албан ёсоор танилцаж эмч эмнэлгийн ажилтан, ажилчдад "Цэвээний ван" ном айлдаж эмнэлгийн цаашдын үйл ажиллагааг дэмжиж Энэтхэгийн талаас туслахаа илэрхийлжээ.

Тус эмнэлгийн дарга Ж.Хатанбаатар БНЭУ-д ажлаар явж байхдаа Олон улсын сэтгэл зүйн эмчилгээний академийн ерөнхийлөгч, оюун санааны их удирдагч С.Гоенка-тай уулзаж Монгол оронд уламжлалын дагуу хөгжиж ирсэн "Бодь" бясалгалын тухай түүхийн сурвалжтай харьцуулан ажиллаж байгаагаа танилцуулснаар уг академаас дэмжлэг авах, багш, туслах багш бэлтгэх үйл ажиллагааг эхэлсэн нь сэтгэл зүйн эмчилгээ явуулж эхлэх үндэс болсон нь Монголын уламжлалт эмчилгээний бие болон сэтгэлийг эмчилдэг цогц аргад шилжсэн эхлэл болсон билээ.

Бурхан шашны тэргүүн 14 дүгээр далай лам 1994 оны 5 сард Монгол улсад албан ёсны айлчлал хийх үедээ Элэгний Эмгэг Эмчлэх Монгол Эмнэлэг Төвийн ажил байдалтай танилцаж, Түвдийн анагаах ухааны эмчилгээний зарим зүйл нь ойролцоо байгааг тэмдэглэж мэргэжилтэн солилцох санал тавьжээ.

Айлчлалын үеэр хийсэн гэрээний дагуу 1994 оны 6 сард БНЭУ-ын Дарамсала хот дахь Далай ламын эмнэлэг зурхайн их сургуульд мэргэжилтэн солилцож ажиллах программын дагуу нийт 8 их эмч, эмийн 2 мэргэжилтэн ажиллуулснаар эмч, эмийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлж эхэлжээ.



Энэ үеэс тус эмнэлгийн эмийн үйлдвэрт нийт 220-иод нэр төрлийн 2082,33 кг эм,тан, 4,2 кг эрдэний их найрлагат эм үйлдвэрлэж, үүнээс 35 төрлийн эмийг шахмалаар хийх технологийн зааврыг Монголд анх удаа боловсруулан гаргаж эдгээр эмүүдээс 427,8 кг 5,2 сая төгрөгийн эмийг шахмалаар 55 төрлийн 9143040 төгрөгийн 6719 кг эмийг үрлээр хийж уламжлалт анагаах ухааны хөгжилд эмийг орчин үеийн шаардлагад хангасан хэлбэрт шилжүүлэх, ажлыг Монгол

улсын хэмжээнд анх удаа хийж байна. Мөн үйлдвэрийн технологийн заавруудыг шинээр батлуулан мөрдөн ажиллаж, бүх эмэнд технологийн зааврыг боловсруулж мөрдөж ажиллаж байна. Өөрийн эх орны байгалиас нийт 28 төрлийн 212 кг эмийн ургамлыг түүж хатааж, цэвэрлэж, савлаж эмийн түүхий эд болгож стандартын дагуу бэлтгэдэг бөгөөд эмэнд хэрэглэгддэг манай оронд байдаггүй зарим нэг эмийн ургамлыг гадаад орноос бэлтгэхэд их анхааран ажиллаж байлаа.

Монгол Улсын Нийслэлийн Засаг даргын 2000 оны 12 дугаар сарын 29-ны 468 тоот захирамжаар Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Элэгний эмгэг эмчлэх монгол эмнэлэг төвийг Уламжлалт Анагаах Ухааны Элэг Судлалын Клиник Төв болгон судалгааны ажлыг давхар хийхээр өөрчилж, бүтэц орон тоог зохион байгуулалтын 5 нэгжтэй, 139 орон тоотой, төвийн дүрмийг баталжээ. Уг дүрэмд: "Нийслэлийн Засаг Даргын дэргэдэх Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв нь элэгний аргах өвчнийг Уламжлалт анагаах ухааны аргаар оношлон, эмчилгээний явц үр дүнг судлан, төгс эмчлэх, эмчилгээний үр дүнг бүрэн төгс болгох үүднээс эмчилгээний клиник, гам заслын сувилал, сэтгэл зүйн эмчилгээний салбар, уламжлалт арга технологиор эм үйлдвэрлэх эмийн үйлдвэр, эмчилгээний үр дүнг орчин үеийн шинжлэх ухааны ололтоор судлан тайлбарлаж дүгнэлт өгөх, шинжилгээ судалгааны хэсэг, эмч, эмийн мэргэжилтнийг уламжлалт анагаах ухааны чиглэлээр бэлтгэх мэргэжлийг дээшлүүлэх сургуультайгаар ажиллах, уламжлалт анагаах ухааны клиникийн үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлэх нарийн мэргэжлийн клиникийн төв болох төсөвт байгууллага юм" гэж хуульчлан зааж өгсөн байна.

Тус төв нь 2003 оны 6-р сард анх удаа УАУ-ны төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусгай зөвшөөрлийг ЭМЯ-аас авсан бөгөөд эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох улсын комиссын шийдвэрээр 703/2003 тоот "Магадлан итгэмжлэл" олгожээ.

Тус төвийн эмийн үйлдвэрийн үйлдвэрлэсэн Монгол агар, Замбагат, Хөгшин оюут, Элэгний тан, Гиван зэрэг 5 төрлийн эм нь Монгол улсын шинэ бүтээлийн патент авч ажилласан.

Энэ хугацаанд орчин үеийн анагаах ухааныг уламжлалт анагаах ухаантай хослуулан эмчилгээний үр ашигтай сонгомол загварыг бий болгосон төдийгүй элэгний өвчний оношлогоо, эмчилгээний нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлдэг клиник төв болтлоо өргөжин бэхжсэн юм.

**Одоо тус клиник төв нь:**

-14 кабинеттай амбулатори

-70 ортой стационари

-30 ортой улсын хэмжээний үйл ажиллагаатай рашаан сувилал, сэтгэл зүйн эмчилгээний салбар

-эмийн үйлдвэр

-шинжилгээ судалгааны хэсэг

-аж ахуйн тасаг зэрэг нэгж хэсгүүдээс бүрдэж нэгдмэл үйл ажиллагааг явуулж байна.

Эмийн үйлдвэр нь БНЭУ болон ХБНГУ, ОХУ, БНХАУ-ын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд байгалийн гаралтай 300-аад нэр төрлийн түүхий эдээр 220 гаруй нэрийн 2,3-3 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эмнэлгийнхээ хэвийн найдвартай ажиллагааг хангаж байна.

Эмийн түүхий эдийнхээ 70%-ийг эх орноосоо бэлтгэж байгалийн гаралтай үндэсний эмийн үйлдвэрлэлийн 75%-ийг үйлдвэрлэн борлуулж, эм нь үрэл, шахмал, ханд хэлбэртэй, харин тан нь нунтаг хэлбэртэй нэг удаагийн уух хэмжээгээр савлагдсан байдаг.

1994-1997 он хүртэл байгууллагын даргын тушаалаар улирлын чанартай гүүний саамны сувилал эхлэн ажиллаж эхлэсэн.

1997 онд нийслэлийн засаг даргын захирамж гарснаар Сувилал сэтгэл зүйн эмчилгээний салбар байнгын үйл ажиллагаатай салбар болон өргөжих эхлэл тавигдсан. Тус сувилал нь Төв аймгийн Долоон хар уул хэмээн нэрлэгдэх газар ажиллан зуны саруудад сувиллуулагчдад эмчилгээний дараах гам засал болон саам эмчилгээг явуулж байлаа

1995-1997 онуудад сэтгэлзүйн эмчилгээний кабинетийг байгууллагын даргын тушаалаар байгуулан эмчлүүлэгчдийн дунд сэтгэлзүйн эмчилгээг явуулж ирсэн бөгөөд Сэтгэлзүйн эмчилгээг явуулснаар өвчтөний өвчин даах чадвар нэмэгдсэн, эдгэрэлт түргэссэн, эмчилгээний үр дүн сайжирсан зэрэг сайн үр дүнгүүд ажиглагдаж байлаа.

1997 онд Нийслэлийн засаг даргын захирамж гарч одоогийн сувиллын байрыг сувилал сэтгэлзүйн эмчилгээ явуулах зөвшөөрөл олгосон нь тухайн үед маш нүдээ олсон шийдвэр байсан юм.

Тухайн байр өмнө нь сүрьеэгийн эмнэлэг байсан уулын амны эмнэлэг гэж нэрлэгдэж байсан байр байсан боловч 90-ээд оны эхээр актанд гарч актлагдсанаас хойш ашиглагдаагүйгээс эвдэрч хэмхрэн цахилгаан сантехникийн шугам сүлжээ болон цонх хаалга нь тоногдсон байр байлаа.

Гэвч энэхүү салбарыг цаашид хөгжүүлэх үйл ажиллагаагаа өргөжүүлэх Хатанбаатар эмчийн чин сэтгэл хүчин зүтгэлийн ачаар нийт хамт олны идэвх зүтгэлээр энэхүү байрны бүтээн босголтын ажил эхлэсэн билээ

Богд-Уул сувилал нь улсын хэмжээний байнгын үйл ажиллагаатай юм. Уламжлалт эм тангийн болон засал эмчилгээг голлон сувилгаа эмчилгээг явуулж байна. Тус сувилал нэг ээлжиндээ 40-60 хүнийг хүлээн авч сувилж байна.

2500 жилийн түүхтэй Випашяна бясалгалын үүх түүх өнөөдөр дэлхий нийтийн сонирхлыг улам ихээр татсаар байгаа. Энэ бясалгалыг 25 зууны тэртээ манайхны ярьж дадсанаар Шагяа хааны түүх Сиддхарта Готама буюу Монголчуудын нэрлэдгээр Бурхан багш өөрийнхөө уйгагүй хөдөлмөр, хичээл зүтгэлээрээ нээн илрүүлсэн гэдэг. Үүний ачаар хүн төрөлхтөн өнөөдөр цаг мөч бүр амьдралын уруудаж өгсөж, зовж жаргаж байдаг бэрх нугачаанд сэтгэлийн зовлонгүй, жинхэнэ аз жаргалтай, эрч хүчтэй амьдрах амьдралын урлагт олон зууны туршид суралцаж ирсэн. 1997 оноос Сэтгэл зүйн эмчилгээг анх удаа нийтийн хэмжээнд хийхээр шийдвэрлэсний дагуу хүүхдийн "Цагаан нуга" зусланд нийтийн 10 хоногийн анхан шатны курс эмчилгээнд хот хөдөөгийн нийт 128 хүнийг хамруулж явуулсан нь Уламжлалт анагаах ухааны эмчилгээний нэг төрөл сэтгэлийг эмчлэх эмчилгээ монголд анх удаа хийгдэж салбарлан хөгжих эхлэлээ тавьсан.



Сэтгэлзүйн эмчилгээ нь Монголчуудын зуунаас зуунд дамжуулан уламжилж ирсэн аргаар хүний стресс, адреналины циклийг илааршуулж бие махбодийн үйл ажиллагааг хэвийн болоход ихээхэн үр дүн үзүүлдэг эмчилгээг хэрэглэсээр хүмүүс өвчин шаналалаасаа богино хугацаанд салж бие организм алдагдал нь хэвийн үйл ажиллагаандаа орж эдгэрэх хугацаа түргэсэн байгаагаараа давуу талтай байна. Сэтгэл зүйн эмчилгээг 1, 8, 10, 20, 30 хоногийн программаар явуулдаг бөгөөд 1997 оноос өнөөдрийг хүртэл нийт 50000 гаруй хүмүүс хамрагдсан байна.

Амбулатори нь орчин үеийн анагаах ухааны тоног төхөөрөмжтэй оношлогооны хэсэг болон уламжлалт анагаах ухааны үндсэн хийгээд туслах эмчилгээний кабинетуудад 10 гаруй их эмчтэйгээр нарийн мэргэжлийн оношлогоог хийж таван цул, зургаан савын өвчнийг эм тангийн үндсэн эмчилгээ болон зүү төөнүүр, алт мөнгөн түрэм, хануур самнуур, иог, цэгийн иллэг, бариа засал зэрэг уламжлалт заслын эмчилгээнүүдийг хийж гүйцэтгэхийн зэрэгцээ хиймэл шүд, физик эмчилгээний кабинетуудаар иж бүрэн үйлчилж байна.

Стационари нь 70 ортой хоёр тасгаас бүрдэж, ээлжийн буюу тасралтгүй үйл ажиллагаагаар өвчтөнийг хүлээн авч хэвтүүлэн орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар хослуулан төгс эмчилдэг.

Аж ахуйн тасаг нь 35 ажилчинтай, өдөрт 150 хүнд үйлчлэх хүчин чадалтай гал тогоо, авто машины граж, 1,2 га талбай бүхий хүнсний ногооны газар зэргээс бүрдэж үйл ажиллагаа явуулдаг. Манай байгууллагын хөмрөгийн түүх нь 1989 оны 1 дүгээр сард үндэс сууриа тавьсан тэр үеэс эхлэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд 1989-2007 оны захирамжлалын болон зохион байгуулалт, санхүү, цалин, өвчтөний түүх зэрэг дотоод үйл ажиллагааны баримт бичгээр байгууллагынхаа архивыг үүсгэн байгуулсан.

Тус төвийн гадаад харилцаа нь улам өргөжин хөгжиж альтернетив анагаах ухааны дэлхийн зөвлөл, алтернетив анагаах ухааны дэлхийн нийгэмлэг болон БНЭУ-ын Варнаса хотын Аюурведийн төв, Дармасала хотын Далай ламын дэргэдэх эмнэлэг зурхайн институт, Япон улсын Токио хотын АУИС-ийн клиникийн эмнэлэг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алша аймгийн төв эмнэлэг, Их Британи Умард Ирландын нэгдсэн вант улсын Хатан хааны нэрэмжит их сургуулийн элэг судлалын төв, ОХУ-ын Буриадын Дорно Дахины Анагаах Ухааны Төв болон Балба, Тайланд, Солонгос улсуудын ажил төрлийн холбоотой эмнэлгийн газруудтай хамтран ажиллаж байна.

БНЭУ-ын Рунжав мужид 2000 онд болсон УАУ-ны дэлхийн зөвлөлийн ээлжит 21-р хуралдаанд тус төвийн 3 хүний бүрэлдэхүүнтэй /ахлагч нь Ж.Хатанбаатар/ төлөөлөгчид оролцож "Монголд УАУ-ны хөгжлийн өнөөгийн байдал" илтгэл тавьж хэлэлцүүлсэн нь өндөр үнэлэлт авсан төдийгүй тус төвийн захирал Ж.Хатанбаатарыг УАУ-альтернетив дэлхийн зөвлөлийн хариуцлагатай нарийн бичгийн даргаар томилжээ.

Мөн энэ хурлын үеэр хуралдсан УАУ-ны дэлхийн нийгэмлэгийн 12-р хуралдаанаас тус төвийг уг нийгэмлэгт гишүүнээр элсүүлж захирлыг нь нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүнээр сонгосон явдал нь Монголын Уламжлалт анагаах ухааныг Монгол улсад хөгжих хөгжлийн явцыг өндрөөр үнэлж байгаагийн нэг тод илрэл юм.

Тус төвийн шинжилгээ судалгааны хэсэг нь анагаах ухааны доктор-2, магистр 3, судалгааны ажилтан-7 нийт арван хоёр хүний бүрэлдэхүүнтэйгээр Монголын уламжлалт анагаах ухааны аргаар хийгдэж байгаа эмчилгээний үр дүнг орчин үеийн шинжлэх ухааны өндөр мэдрэмжит шинжилгээний аппарат дээр тооцон судалж байна. Тэдний судалгаагаар элэгний өвчнийг эмчилж байгаа уламжлалт монгол эм, тан нь элэгний эд эсийг хамгаалах, сэргээх, нөхөн төлжүүлэх, бодисын солилцоог сайжруулах, элгийг хоргүйжүүлэх болон хүний дархлалын ерөнхий үйл ажиллагааг идэвхжүүлдэг болох нь бүрэн нотлогдсон билээ. Манай практик хэрэглээнд хэрэглэгдэж байгаа элэгний эсийн мембраныг бэхжүүлэгч сонгомол үйлчилгээтэй олон найрлагатай хэд хэдэн эмүүдийн үр дүнгийн талаар эрдэм шинжилгээний ажил дагнан хийж олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн нь орчин үеийн анагаах ухааныг уламжлалт анагаах ухаантай хослуулсан эмчилгээний үр дүнг олон улсын хэмжээнд танилцуулахад чухал ач холбогдолтой ажил болсон билээ. Мөн дорно дахины анагаах ухааны International Trust for Traditional Medicine /ITTM/ байгууллагатай хамтран судалгаа шинжилгээний ажлыг хийж байна.

Монгол Улсын Үйлдвэр Худалдааны Яамны үйлдвэрийн танхим зохион байгуулдаг SMET-2001 үзэсгэлэнд тус төвийн эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүний дээж оролцож Монгол улсын Уламжлалт анагаах ухааны хөгжлийн сүүлчийн 70 гаруй жилд анх удаа хийж байгаа их эрдэнийн найрлагат эмүүдээс "Оюут-25" эм нь 2002, 2004 онуудад "Оны шилдэг бүтээгдэхүүн"-ээр шалгарсан төдийгүй, 1993 оны 3-р сард Нийслэлийн Хэрэглэгчдийн Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэгийн найдвартай түнш гэрчилгээний 01 дугаарыг хүлээж авч улмаар "Хэрэглэгчдийн найдвартай түнш" цолын батламжийг 2 удаа хүртээжээ.

2004 оны 9-р сард ЭМЯам, ХАУ-ийн танхим, эм үйлдвэрлэгчдийн холбооны зохион байгуулсан "Эм, эмнэлгийн техник 2004" үзэсгэлэнгээс тус төвийн "Оюут-25" эрдэнийн их найрлагат эм нь "Дотоодын эмийн шилдэг бүтээгдэхүүн" тэргүүн шагналаар шагнагдсан байна.

2009 онд Уламжлалт анагаах ухааны анхдугаар чуулганаар тус төвийн "Ходоодны иж бүрдэл" эм нь шилдэг бүтээлээр шалгарч мөн онд тус төв нь үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулж, Уламжлалт анагаах ухааны эмчилгээ, оношилгоо, эм үйлдвэрлэлийн хөгжилийн түүхэн замналыг харуулсан үзэсгэлэнг зохион байгуулж

Уламжлал ба Шинэчлэл нэртэй онол практикийн бага хуралыг амжилттай зохион байгууллаа.

2010 онд тус төвийн эмийн үйлдвэр нь сүүлийн үеийн дэвшилтэд техник технологийн шинэчлэлийг хийж NANO технологийг ашиглан Зэнэдмэн-139 цуврал бүтээгдэхүүнийг уламжлалт эм үйлдвэрлэлд анх удаа капсул, ханд хэлбэрээр үйлдвэрлэн эмчилгээ үйлчилгээндээ нэвтрүүлж судалгаа шинжилгээг хийн ажиллаж байна.

Нийслэлийн Засаг Даргын Дэргэдэх Уламжлалт Анагаах Ухааны Элэг Судлалын Клиник Төв нь одоо төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээг улсын хэмжээнд Уламжлалт Анагаах Ухааны аргаар иж бүрэн, цогц чанартай үзүүлж, орчин үеийн шинжлэх ухааны ололттой хослуулан үйл ажиллагаандаа нэвтрүүлж, өндөр мэргэшсэн чадварлаг боловсон хүчнээр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжинд хүрч үйлчлэх эрхэм зорилго тавин ажиллаж байна.